



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 06 сарын 14 өдөр

Дугаар 4/274

Мандалговь

Г Тусгай зөвшөөрлийн эрх сунгах,  
хүчингүй болгох тухай

Монгол Улсын "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай" хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.3 дахь заалт, 7 дугаар зүйлийн 7.2, 7.4, 9 дүгээр зүйлийн 9.1.2, 16 дугаар зүйлийн 16.2.5 дахь заалт, "Архидан согтуурахтай тэмцэх тухай" хуулийн 4 дүгээр зүйлийн 4.7 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.2, 6.3 дахь заалт, 7 дүгээр зүйлийн 7.1.7, 7.1.8, 14 дүгээр зүйлийн 14.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Сайнцагаан сумын "Хосгарьд магнаг" ХХК-ны хүнсний дэлгүүрийн архи согтууруулах ундаа (спиртийн өндөр болон сул агууламж) худалдан борлуулах тусгай зөвшөөрлийн эрхийг 2018 оны 6 дугаар сарын 14-ны өдрөөс 2019 оны 6 дугаар сарын 14-ны өдөр хүртэл хугацаагаар сэргээсүгэй.

Хоёр. Хулд сумын "Төгрөгийн итгэлцэл" ХХК-ны хүнсний дэлгүүрийн архи согтууруулах ундаа (спиртийн өндөр болон сул агууламж) худалдан борлуулах тусгай зөвшөөрлийн эрхийг 2018 оны 6 дугаар сарын 14-ны өдрөөс 2020 оны 6 дугаар сарын 14-ны өдөр хүртэл хугацаагаар сунгасугай.

Гурав. Сайнцагаан сумын "Дэлгэрномт Ундраа" ХХК-ны хүнсний дэлгүүрийн архи согтууруулах ундаа худалдан борлуулах тусгай зөвшөөрлийн эрхийг хүчингүй болгосугай.

Дөрөв. Тусгай зөвшөөрлийн эрх олгогдсон "Хосгарьд магнаг", "Төгрөгийн итгэлцэл", ХХК-ны худалдааны газрын ажиллах цагийн хязгаарыг 09.00 -21.00 цаг хүртэл хугацаагаар баталсугай.

Тав. Тусгай зөвшөөрлийн эрхийг олгосон шийдвэрийг холбогдох газруудад хуулийн хугацаанд мэдэгдэхийг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Н.Эрдэнэ-Очир), тухайн аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар (Ц.Сугаржав), Татварын хэлтэс (М.Туяацэцэг), Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат), сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О. БАТ-ЭРДЭНЭ

0200732